



## НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР ОНӨААТҮГ ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 10 сарын 02 өдөр

Дугаар А/Б1

Улаанбаатар хот

Тушаал хүчингүй болгож,  
Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10, “Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын дүрмийн 6 дугаар зүйлийн 6.11, “Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газарт дотоод хяналтыг зохион байгуулах журам”-ын 3.1 дэх заалтыг тус тус үндэслэн тушаах нь:

1. Улс, нийслэл, орон нутгийн өмчийн хөрөнгө оруулалтаар он дамжин хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээ болон 2023 оны барилга байгууламжийн угсралт, засварын ажлуудын хэрэгжилтийн явц, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангаж буй байдалд хяналт шалгалт хийх “Ажлын хэсгийн бүрэлдэхүүн”-ийг нэгдүгээр, төсөл, арга хэмжээнд хяналт тавих “ажлын удирдамж”-ийг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ерөнхий инженер (Т.Оргил-Эрдэнэ)-т даалгасугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдон Газрын даргын 2022 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн А/53 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Б.МӨНХБАТ



Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын  
 даргын 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн  
 А/81 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралт



### АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

д/д	Дүүргийн нэр	Ерөнхий хяналт тавих	Хяналт тавих
1.	Сонгинохайрхан дүүрэг	Х.Батхүү – Мэдээллийн технологийн хэлтсийн дарга	С.Соёмбо Б.Одончимэг А.Алтантулга Ж.Мөнхнаран Б.Туяажаргал С.Ариунтуул
2.	Баянгол дүүрэг	Н.Эгиймаа – Төлөвлөлт судалгааны хэлтсийн дарга	Л.Гансүх Х.Орхонсэлэнгэ Д.Золжаргал У.Одгэрэл С.Ариунтуул А.Алтантулга Э.Одчимэг Г.Бат-Эрдэнэ
3.	Хан-Уул дүүрэг	Б.Лхагважав – Зураг төслийн хэлтсийн дарга	Г.Ганпүрэв Э.Оргил У.Одгэрэл
4.	Чингэлтэй дүүрэг	С.Цэдэнсодном – Захиргааны хэлтсийн дарга	Г.Мөнх-Эрдэнэ Э.Оргил У.Одгэрэл Э.Одчимэг
5.	Сүхбаатар дүүрэг		Ч.Баярхүү Э.Оргил У.Одгэрэл
6.	Баянзүрх дүүрэг	Д.Пүрэвжав - Санхүү, аж ахуйн хэлтсийн дарга	Г.Мөнхболд Г.Буянжаргал Э.Одчимэг Б.Мөнхзаяа Р.Дамбадаржаа Б.Амгаланцэцэг А.Дамбадагва
7.	Багахангай дүүрэг	Б.Батбилэг - Хууль, дотоод хяналтын хэлтсийн дарга	Л.Болорчулуун Х.Энхбаатар У.Одгэрэл Р.Дамбадаржаа
8.	Багануур дүүрэг		Л.Болорчулуун Х.Энхбаатар У.Одгэрэл Р.Дамбадаржаа
9.	Налайх дүүрэг		Л.Болорчулуун Х.Энхбаатар У.Одгэрэл Б.Амгаланцэцэг А.Дамбадагва



Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын  
даргын 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн  
А/Б/1 дүгээр тушаалын хоёрдугаар хавсралт



## ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНД ХЯНАЛТ ТАВИХ АЖЛЫН УДИРДАМЖ

### Нэг. Зорилго

Өмнөх оны улс, нийслэл, орон нутгийн өмчийн хөрөнгө оруулалтаар он дамжин хэрэгжиж байгаа болон 2023 оны барилга байгууламжийн угсралт, засварын ажлуудын хэрэгжилтийн явц, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангаж буй байдалд хяналт шалгалт хийх, төсөл, арга хэмжээнд хяналт тавих, ажлыг эрчимжүүлэх, гэрээний хугацаанд ашиглалтад оруулах ажлыг зохион байгуулахад удирдамжийн зорилго оршино.

### Хоёр. Зохион байгуулалт

2.1. Хэлтсийн дарга нар хуваарийн дагуу дүүргүүдийг хариуцаж ажиллана.

Үүнд:

- Хууль, дотоод хяналтын хэлтсийн дарга Б.Батбилэг-Багануур, Багахангай, Налайх дүүргүүд
- Захиргааны хэлтсийн дарга С.Цэдэнсодном – Сүхбаатар, Чингэлтэй дүүрэг
- Санхүү, аж ахуйн хэлтсийн дарга Д.Пүрэвжав – Баянзүрх дүүрэг
- Зураг төслийн хэлтсийн дарга Б.Лхагважав – Хан-Уул дүүрэг
- Төлөвлөлт судалгааны хэлтсийн дарга Н.Эгиймаа – Баянгол дүүрэг
- Мэдээллийн технологийн хэлтсийн дарга Х.Батхүү – Сонгинохайрхан дүүрэг

2.2. Төсөл, арга хэмжээнд хяналт тавих ажлын хуваарийг Барилга захиалагчийн хэлтэс 14 хоногт 1 удаа гаргаж газрын даргаар батлуулна.

### Гурав. Хугацаа

3.1. Хяналтын ажил нь төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн угсралт, засварын ажил дуусаж, байнгын ашиглалтад орох хүртэл үргэлжилнэ.

### Дөрөв. Тайлан

4.1. Ажлын явцыг 7 хоног бүр газрын шуурхай хуралд танилцуулна.

4.2. Төсөл, арга хэмжээ цаашид хэрэгжих боломжгүй, тасалдсан, зогссон тохиолдолд шийдвэрлэх арга замыг эрэлхийлэн Даргын зөвлөл, техникийн зөвлөлд хэлэлцүүлж тухайн тойргоос сонгогдсон Улсын Их Хурлын гишүүд, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчид болон нийслэлийн Засаг даргын Тамгын газар, мэргэжлийн байгууллага, гүйцэтгэгч аж ахуйн нэгж байгууллагатай хамтран ажиллана.